

Стандартчилсан нэр томъёоны сан дахь дан бүтэцтэй нэр томъёоны дагаврын байр, харьцаа**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ**

Түвдэндоржийн БАТБЯМБА*

*Монгол Улс, Улаанбаатар, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Компьютер хэл шинжлэлийн лаборатори***Received:** Apr 15, 2024**Revised:** October 06, 2024**Accepted:** October 25, 2024

Хураангуй: Бид 2022-2024 онд ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарт хэрэгжүүлж буй “Монгол нэр томъёоны стандартын судалгаа (Нэр томъёог боловсруулах арга, зарчмын олон улсын стандартыг нутагшуулах)” суурь судалгааны төслийн хүрээнд Монгол Улсад хэрэглэж буй 85 стандартын 10387 нэр томъёоны сан бүрдүүлэв. (Батбямба, 2023). Улмаар тус сангаа төрөлжүүлэн ангилж, нэр томъёог бүтээж байгаа дагаврын байр, харьцаа, гүйцэтгэх үүрэг, давтамж, бүтээлчээр хэрэглэгдэж байгаа эсэх, илэрхийлж байгаа утгын оновчтой болсон зэрэг асуудлын талаар өөрсдийн саналыг дэвшүүлж, нэгтгэн дүгнэхийг зорьсон.

Бид судалгаандаа эх хэлний боловсруулалтад өргөн хэрэглэдэг “Онцлогийг тодорхойлох арга” (Attribute Description Method)-аар материалын сандаа тэмдэг хадсан бөгөөд цахим сангийн боловсруулалтаа МУИС-ийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Инженерчлэлийн Сургуулийн харьяа судалгааны лабораторийн боловсруулсан “Монгол хэл боловсруулалтын үзүүлэн хуудас (htt4)”-ыг гараар тэмдэглэгээ хийх аргатай хослуулсан.

Энэхүү судалгаа нь нэр томъёо товч тодорхой, салаа утгагүй бөгөөд оновчтой байхаас гадна нэр томъёог бүтээж байгаа үгийн утга, ухагдахуун нь хоорондоо яв цав тохирч байх ёстой гэсэн нэр томъёоны үндсэн шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Бидний бүртгэлээр тус санд 1249 буюу нь дан бүтэцтэй нэр томъёо илэрсэн бөгөөд “хөрс, аянга, ган, зуд, ууж” зэрэг үндсээрээ байгаа нэр үг, “зузаан, дулаан, товгор, хотгор, налуу” зэрэг тэмдэг нэр, “буцаах, дагалдах, татах,

* © Т.Батбямба, 2024

Email: batbyamba_1@mas.ac.mn,  <https://orcid.org/0009-0004-4337-961X>

хэрчигдэх, хянах” зэрэг үйл язгуур + үйлээс үйл үг бүтээх дагавар залгаж бүтсэн үйл үг, “усгүйжүүлэх, идэвхжүүлэх, өрөмдөх, ангилах, хөөсрүүлэх” зэрэг нэр язгуур + нэрээс үйл үг бүтээх дагавар + хэвийн дагавар залгаж бүтсэн үйл үг илэрсэн нь стандартчилсан нэр томъёоны бүтцийн талаар өөрсдийн саналаа нэмэрлэхэд чухал нөлөөг үзүүлээ.

Түлхүүр үг: нэр томъёоны стандарт, бүтэц, үгсийн аймаг, нэр томъёо оноох боловсруулах зарчим

The Position and Relation of Single Terms in the Standartized Term Corpus

BATBYAMBA Tuvdendorj

Department of Applied Linguistics, the Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: We created an electronic corpus based on 85 standards used in Mongolia as part of the basic research project “Research on Mongolian Terminology Standards (Localization of International Standards of Terminology Development Methods and Principles)” conducted by the Department of Applied Linguistics of the Institute of Language and Literature, MAS, from 2022 to 2024 (Batbyamba, 2023).

The corpus was categorized and diversified, and we aimed to present and summarize our suggestions on various issues, including affixes, relationships, functions, frequency of use, creativity, and the optimality of the meanings expressed. For this research, we applied the Attribute Description Method, widely used in native language processing, to analyze our material database. The electronic database processing was carried out by the research laboratory affiliated with the School of Applied Science and Engineering at NUM. The study of affixes that form standardized terms is crucial to determine whether the terms align with the basic requirement that a word's meaning should be consistent with the concept of the term.

According to our findings, 1,249 words with a single term were identified in the corpus, including nouns with roots such as *хөрс*, *аянга*, *ган*, *зуд*, and *ууж*; adjectives like *зузаан*, *дулаан*, *товгор*, *хотгор*, and *налуу*; and verbs formed by adding a root + action to create a verb, such as *буцаах*, *дагалдах*, *татах*, *хэрчигдэх*, and *хянах*.

Additionally, we found terms like *усгүйжүүлэх*, *идэвхжүүлэх*, *өрөмдөх*, *ангилах*, and *хөөсрүүлэх*, which involve adding an affix to a noun root to form a verb. This has a significant impact on shaping ideas about the structure of terms.

Keywords: terminology standards, structures, parts of speech, principles of creating and processing terms

1. Удиртгал

Нэр томъёог стандартчилахдаа ямар шаардлагыг баримтлах вэ? Нэр томъёо ер нь ямар байвал зохих вэ? гэдэг асуултад хариулт өгөх шаардлага байнга гардаг.

Учир нь нэр томьёог зөв оноож, боловсруулж, жигдэлснээр орчуулга, зөв бичих дүрэм, хэлний хэм хэмжээ зэрэг бусад зүйл нь аяндаа цэгцэрдэг.

1740-1742 онд зохиогдсон “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг” номд суурилсан нэр томьёо орчуулах, оноох, тогтоох, боловсруулах, жигдлэх ажил нь тасралтгүй үргэлжилсээр орчин цагтай золгосон. (Батбямба, 2023) бөгөөд Монгол Улсын хувьд Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд 1924 онд “Улсын нэр томьёоны комисс” байгуулахаар шийдвэрлэсний дараа жил буюу 1925 онд нэр томьёоны байнгын комиссыг ажиллуулж эхэлсэн тухайн цаг үеийг нэр томьёог судлах, шинжлэх ухааны ул суурьтай судалгаа хийх, судалгааны үр дүнд нэр томьёог зөв оновчтой оноох, тогтоох, боловсруулах, жигдлэх хийгээд сурталчлан таниулах, хэрэглэх ажлын эхлэлийн шанг тавьсан гэж үздэг.

Энэ цаг үеэс хойш өдгөө хүртэл монгол утга зохиолын хэлний нэр томьёог бүтэх арга, илтгэх утга, гүйцэтгэх үүрэг хийгээд давтамж хэрэглээний асуудлыг судлаачид судалж, судалгааны өгүүлэл, ном, сурах бичиг, цуврал, толь бичиг, гарын авлага хэвлүүлснээс гадна хурал, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулж, энэ чиглэлийг судалгааг эргэлтэд оруулах, төр засгийн анхааралд тогтмол хүргэх талаар арга хэмжээг авсаар ирсэн. Тухайлбал, Нэр томьёонд холбогдох ажлуудыг гардан гүйцэтгэж байгаа байгууллагуудын нэг нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар юм.

Тус салбар нь нийтээр хэрэглэж буй нэр томьёоны стандартыг дахин хянах, улам боловсронгуй болгох шаардлагыг харгалзан үзсэний суурь дээр нэр томьёоны онолын чиглэлээр *Монгол хэлний нэр томьёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж* (Гэрэлмаа, 2020), *Нэр томьёоны орчуулга судлал* (Мөнхцэцэг, 2020), *Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томьёо* (Шинэбаяр нар, 2020) гэсэн гурван сэдэвт бүтээл, *Нэр томьёоны стандарт дахь гадаад нэр томьёоны хэрэглээ* (Амартүвшин, 2023), *Стандарт дахь нэр томьёоны бүтцэд хийсэн тоон шинжилгээ* (Батбямба, 2023), *Хуучин үгийг нэр томьёоны үүргээр хэрэглэх нь* (*Монгол Улсын стандартчилсан нэр томьёоны хүрээнд*) (Гэндэнпил, 2023), зэрэг өгүүллийг хэвлүүлснээс гадна 2022 оны 7 сард “Нэр томьёо ба шинжлэх ухаан, технологийн хөгжил-2022” олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурлыг 14 орны 60 гаруй эрдэмтэн судлаачдын хүрээнд зохион байгуулсан. Мөн Хэлний бодлогын үндэсний зөвлөл хамтран Улсын нэр томьёоны комисс үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулан “Нэр томьёо ба шинжлэх ухаан, технологийн хөгжил-2024” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Төрийн ордонд Монгол, Австри, Швейцар, Япон, Солонгос, ОХУ, Колумб, Финланд, БНХАУ зэрэг 9 улсын 57 илтгэгчийн хүрээнд зохион байгуулж, нэр томьёо оноон боловсруулах олон улсын болон дотоодын туршлага, хэлний технологи, стандартчиллын талаар илтгэлийг хэлэлцүүлж, салбар бүрийн нэр томьёоны асуудал, хөгжлийн чиг хандлага, стандартад гол анхаарлаа хандуулах талаар ярилцсан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөл болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн хамтран боловсруулж, хөгжүүлж байгаа <https://terminology.mn/> цахим сайтад Монгол Улсын стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй хүчин төгөлдөр хэрэгжиж буй 6532 стандартаас 85 нэр томьёоны стандартыг сонгон авч нэр томьёоны тодорхойлолтуудыг түүвэрлэн нэгтгэж, толь бичгийн материалын санг бүрдүүлснийг англи, монгол цагаан толгойн дарааллаар танилцуулжээ. (Батбямба, 2023).

Гэвч нийтээр хэрэглэж буй нэр томьёоны стандартыг дахин хянах, улам боловсронгуй болгох шаардлага тулгарсаар байгаа тул шинжлэх ухааны ул суурьтай, тооцоотой судалгаа хэрэгтэй юм. Иймээс бид өөрсдийн бүрдүүлж, боловсруулсан стандартчилсан нэр томьёоны цахим сандаа түшиглэн, дан бүтэцтэй нэр томьёог сонгож, эдгээр нэр томьёо нь дагаврын арга (идэвхтэй нэр болон үйл идэвхгүй язгуур, идэвхгүй дүрслэх болон дуурайх язгуураас үг бүтэх), авиа сэлгэх арга, үг товчлох арга зэрэг үг бүтэх үндсэн ба туслах аргуудын алинаар нь хэрхэн бүтсэнийг судалж, дагаврын бүтэц, харьцаа нь монгол нэр томьёо оноох, боловсруулах хэм хэмжээнд хэр нийцэж буйд ажиглалт хийв.

Энэхүү өгүүлэл нь 1. Удиртгал, 2. Судалгааны арга зүй, 3. Судалгааны хэсэг, 4. Дүгнэлтээс гадна ном зүй, хавсралт, талархал гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

2. Судалгааны арга зүй

Бид энд дан бүтэцтэй нэр томьёо бүтэх арга хийгээд үг бүтээж байгаа дагаврын тохиолдох байрыг тодорхойлохын тулд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны хамтран бүрдүүлсэн Монгол Улсын аж үйлдвэр, нийтийн үйлчилгээний салбарын 85 стандартын 10387 нэр томьёо, тодорхойлолт бүхий анхдагч материалын санг судалгааны эх хэрэглэгдэхүүнээр ашиглаж хам цаг (synchrony)-ийн судалгаа хийсэн болно.

Энэхүү стандартчилсан нэр томьёоны цахим санд суурилсан судалгааны үндсэн арга нь үгсийг материалын санд бүртгэх бөгөөд хэл зүй-үгийн сангийн нарийн задлалтаар тэмдэгжүүлэн бүрдүүлбэрийн задаргаа хийх, хам бичвэрийн аргаар хам сэдвээс үгсийг ялгах, улмаар үгсийн сангийн хэрэглээний чанарыг үнэлэх, үгийн бүтэц, хэрэглээн дэх давтамжийг тогтооход Японы Васеда их сургуулийн Шинжлэх ухаан, инженерчлэлийн факультетын профессор Лоренс Антоны боловсруулсан AntConc ([http5](http://www.antcon.org/)) болон EXCEL программын хэрэгслүүдийг түлхүү ашиглав.

Өмнөх судалгаандаа (Батбямба, 2023) бид эх хэлний боловсруулалтад өргөн хэрэглэдэг “Онцлогийг тодорхойлох арга” (Attribute Description Method)-аар материалын сандаа тэмдэг хадаж, стандартчилсан нэр томьёоны цахим санд бүртгэгдсэн 10387 нэр томьёоны 1249 буюу 12.02 хувийг нэг үгээс бүтсэн дан

нэр томьёо, 3481 буюу 33.51 хувийг хоёр үгээс бүтсэн, 2611 буюу 25.14 хувийг гурван үгээс бүтсэн нийлмэл нэр томьёо тус тус эзэлсэн зэрэг нэр томьёоны бүтцийн тооцооллын үр дүнгээ дурдсан бол энэхүү судалгаандаа нэр томьёоны цахим сангаа төрөлжүүлэн ангилж, нэр томьёог бүтээж байгаа дагаврын гүйцэтгэх үүрэг, давтамж, бүтээлчээр хэрэглэгдэж байгаа эсэх, илэрхийлж байгаа утгын оновчтой болсон эсэхийг тодруулах зорилгынхоо хүрээнд уг цахим сандаа дараах алхам дарааллаар ажиглалт хийв. Үүнд:

1. Төрөлжүүлэн ангилах;
2. Төрөлжүүлсэн нэр томьёоныхоо бүтцийг тодорхойлох;
3. Зарим нэр томьёог дахин боловсруулах, оновчтой болгох талаар өөрсдийн саналыг дэвшүүлж, нэгтгэн дүгнэх зэрэг болно.

2.1 Төрөлжүүлэн ангилах

Цахим санг байгуулж, боловсруулахад хамгийн эхэнд шаардагддаг зүйл бол өгөгдлүүдийг төрөлжүүлж, ангилах явдал юм. Учир нь судалгааны үр дүнг тооцоололд суурилж гаргахад жигдэлсэн өгөгдөл дээр ажиллах шаардлагатай байдаг. Иймээс бид

1. DataSource хуудсанд аливаа өөрчлөлт ороогүй эх сурвалж өгөгдөл дээр ажиллаж, стандарт тус бүр дотор ижил утга, тодорхойлолт бүхий давхардсан нэр томьёо байгаа эсэхийг хянаж, жигдлэв. Улмаар стандарт тус бүрийн баганыг 'Excel Table' болгон хөрвүүлж тус бүрд 'st_' гэсэн угтвартай нэр өгөв.
2. DataCleaning хуудсанд өгөгдлүүдийг дараах алхмын дагуу цэвэрлэв.

=TRIM(CLEAN(LOWER(cl_1[Class 1]))), /'-

Үл үзэгдэх тэмдэгтүүдийг устгав. Line Break, Grouping гэх мэт тэмдэгтийг (=clean) устгав.

'- Эхлэл ба төгсгөлийн хоосон зайг устгав (=trim).

Материалын сангуудаа хэвлэмэл эх хэрэглэгдэхүүнтэй тулгаж, зөв бичих дүрмийн алдааг хянаж, засаад, тооцоолол гаргахад бэлэн болгов. Мөн нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, тайлбарлан бичих зэрэг олон аргыг хэрэглэв.

Боловсруулахад бэлэн болсон материалын сангаа дэс дугаар, стандартын төрөл, стандартын дугаар, нэр томьёоны стандартын харьяалагдах салбарын нэр, стандартчилсан нэр томьёо, англи орчуулга, орос орчуулга, нэр томьёоны тодорхойлолт гэсэн үндсэн найман зүйлээр ялган ангилав.

Мөн тухайн судалгааны ажлын зорилготой уялдуулан, нэр томьёоны дан ба нийлмэл бүтэц, монгол ба гадаад үг, үгийн дэлгэрэнгүй бүтэц гэсэн нэмэлт онцлогийн тасалбарыг хадаж, төрөлжүүлэн ангилахад бэлэн болгов. Ийнхүү материалын санд боловсруулалт хийж, хөмрөг хэл шинжлэлийн судалгаанд түгээмэл мөрддөг “Баталгаат, тэмдэглэгээт сан”-аа байгуулснаар дараагийн алхам болох стандартчилсан нэр томьёоны бүтэц дэх дагаврын байрлалыг тогтоох үндсэн нөхцөлийг бүрдүүлэв.

2.2 Төрөлжүүлсэн нэр томьёоныхоо бүтцийг тодорхойлох

Өмнөх судалгаанд бид материалын сандаа тэмдэг хадаж, =IF(LEN(TRIM(B2))=0,0,LEN(TRIM(B2))-LEN(SUBSTITUTE(B2," ",""))+1) томьёо ашигласнаар, дан болон нийлмэл бүтэцтэй нэр томьёог тодорхойлсон бол тус судалгаандаа МУИС-ийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Инженерчлэлийн Сургуулийн харьяа судалгааны лабораторийн боловсруулсан “Монгол хэл боловсруулалтын үзүүлэн хуудас (htt4)”-ыг гараар тэмдэглэгээ хийх аргатай хослуулж ашиглав (Хүснэгт №1). Учир нь материалын сан дахь дан бүтэцтэй нэр томьёоны үгийн аймгийн автомат болон нэрлэсэн нэгжийн тэмдэглэгээний танилтын хувь хангалтгүй байсан учраас үгийн бүтэц дэх дагаврын байрлалыг нэмэлтээр гараар тэмдэглэсэн.

Хүснэгт №1. Стандартчилсан нэр томьёоны үгийн бүтэц ба үгийн аймгийн тооцоолол

№	Үндэс	Үгийн аймаг	Нэрлэсэн нэгж	Үгийн бүтэц дэх дагаврын байрлал
1	Борлуулагч	[борлуулагч+N+Sg+Nom]	N	Y+уул+гч
2	Худалдагч	[худалдагч+N+Sg+Nom]	N	Y+гч
3	Таглаа	[тагла+V+Vdpr, тагла+V+Vvc, таглаа+N+Sg+Nom]	VD	H+л+aa
4	Салаалагч	[салаал+V+Vdo]	N	Y+aa+л+гч
5	Цуравдагч	[цуравд+V+Vdo]	N	H+д+гч

3. Судалгааны хэсэг

Монгол хэл нь залгамал бүтэцтэй бөгөөд язгуурын араас дагавар залгаж үндэс үүсгэх, нөхцөл залгаж үг хувилгадаг онцлогтой. Энэ шинжийг шинэ үг бүтээх боломжийн талаас харахад нугалмал болон тусгайлаг хэв шинжийн хэлнээс хязгаарлагдмал байдалтай. Учир нь, монгол хэлний үгийн язгуурын өмнө угтвар болон угтвар үгийг залган шинэ үг үүсгэдэггүйтэй холбоотой. Монгол хэлний бүтцийн онцлогоос хамаарч үг бүтээх түүнчлэн шинэ нэр томьёо бүтээх үндсэн арга нь язгуурт дагавар залгах нийлэг арга, хоёр өөр язгуур нийлж шинэ үг бүтээх задлаг арга гэдгийг судлаачид нэгэнт тогтоожээ.

Бүртгэлээс үзвэл, материалын санд бүртгэгдсэн 1249 дан бүтэцтэй нэр томьёоны 434 нь үндсээрээ, 516 нь дагаврын аргаар, 300 нь гадаад үг байна. Гадаад үгсийн 23 нь дагаврын аргаар, 277 нь үндсээрээ байна (Батбямба, 2023).

3.1. Анхдагч язгуурт залгавар залгаж бүтсэн нэр томьёо

Бид стандартчилсан нэр томьёоны цахим санд бүртгэгдсэн нэр томьёо (язгуур + дагавар)-ны бүтэц дэх дагаврын байрлалыг

- А. Анхдагч нэр язгуурт нэр үг бүтээх дагавар залгаж бүтээсэн нэр томьёо;
- Б. Анхдагч тэмдэг нэр язгуурт нэр үг бүтээх дагавар залгаж бүтээсэн нэр томьёо;
- В. Анхдагч үйл язгуурт дагавар залгаж, нэр үг бүтээсэн нэр томьёо;
- Г. Дүрслэх язгуурт дагавар залгаж, нэр үг бүтээсэн нэр томьёо гэсэн 4 хэсэгт авч үзэж, судалгааны үр дүнг өгүүллээ. Үүнд:

А. АНХДАГЧ НЭР ЯЗГУУР + ДАГАВАР = НЭР ҮГ

- Анхдагч нэр язгуурт -вч дагавар залгаж бүтээсэн 9 нэр томьёо байна.
 - *өлгий + вч = өлгийвч* (MNS 6827: 2020)
 - *хошуу + вч = хошуувч* (MNS 0639: 2016)
- Анхдагч нэр язгуурт -дэл дагавар залгаж бүтээсэн 1 нэр томьёо байна.
 - *хүч + дэл = хүчдэл* (MNS ISO 6701-1: 2010)
- Анхдагч нэр язгуурт -ч дагавар залгаж бүтээсэн 1 нэр томьёо байна.
 - *шуудан + ч = шууданч* (MNS 0515: 2015)
- Анхдагч нэр язгуурт -чин дагавар залгаж бүтээсэн 2 нэр томьёо байна.
 - *мах + чин = махчин* (MNS 3474: 2003)
 - *зөгий + чин = зөгийчин* (MNS 6827: 2020)
- Анхдагч нэр язгуурт -нцар (-нцэр) дагавар залгаж бүтээсэн 3 нэр томьёо байна.
 - *бүл + нцэр = бүлэнцэр* /Нэг бүлээс үрвэлдэйтэй болон тэжээлтэй сархиагуудыг дээр нь суусан зөгийн хамт таслан авч өөр гэрт байрлуулсны дараа хээлтэй эсвэл хээлгүй эх тавьж, тусад нь өсгөн бойжуулж эхэлж буй шинэ бүл/ (MNS 6827: 2020)
 - *тэрэг + нцэр = тэргэнцэр* /Төмөр зам дээгүүр вагоныг чиглүүлэн, тэвшнээс ирэх бүх ачаалалт, хүчийг зам төмөрт дамжуулан, хөдөлгөөнийг хамгийн бага эсэргүүцэлтэйгээр, алгуур зөөлөн явах явалтыг хангасан иж бүрдэл эд анги. Түүний бат бэх, найдвартай, аюулгүй байдлаас нь хөдөлгөөний хурд хамаарах ба зориулалт, голын тоо, нумын дүүжин, тэвшнээс ирэх ачааллыг дамжуулах байдал, гүүшингийн холболтын төхөөрөмж, арлын хийц зэргээр ялгагдах вагоны үндсэн эд анги/ (MNS 6387-3: 2013)

Б. АНХДАГЧ ТЭМДЭГ НЭР ЯЗГУУР + ДАГАВАР = НЭР ҮГ

- Анхдагч тэмдэг нэр язгуурт -лж дагавар залгаж бүтээсэн 1 нэр томьёо байна.
 - *хавтгай + лж = хавтгайлж* (MNS ISO 6701-1: 2010)

Анхдагч тэмдэг нэр язгуурт -вч дагавар залгаж бүтээсэн 1 нэр томъёо байна.

- $бүдүүн + вч = бүдүүвч$ /Системийн үндсэн хэсгүүд буюу үйлдлүүдийн хоорондох харилцааг үзүүлэхийн тулд шугамаар холбогдсон блокуудаар дүрсэлсэн диаграмм. ТАЙЛБАР: Бүдүүвчийг зөвхөн биет төхөөрөмжийн хувьд хэрэглэнэ гэж ойлгож болохгүй/ (MNS ISO 2392-1: 1999)

В. АНХДАГЧ ҮЙЛ ЯЗГУУР + ДАГАВАР = НЭР ҮГ

- Анхдагч үйл язгуурт -аа дагавар залгаж, нэр үг бүтээсэн 2 нэр томъёо байна.
 - $ут + аа = утаа$ /Шатлагын үед үүсэн агаарт үзэгдэх хатуу, шингэн ба хийн бодисууд/ (MNS 3838: 1985)
 - $ач + аа = ачаа$ /Агаарын тээвэр, төмөр замаар тээвэрлэгдэх шуудан, шуудангийн илгээлтээс бусад төрлийн (өөр) карго-ачаа/ (MNS 0515: 2015)
- Анхдагч үйл язгуурт -аас дагавар залгаж, нэр үг бүтээсэн 9 нэр томъёо байна. Жишээ нь:
 - $тул + аас = тулаас$ /Хамар хана (5.2.45) эсвэл даацын ханан (5.1.7) дахь босоо бүтээцийн элемент (5.1.3), бүлэг босоо элементийн нэг нь/ (MNS ISO 6701-1: 2010)
- Анхдагч үйл язгуурт -бар⁴ (-вар⁴) дагавар залгаж, нэр үг бүтээсэн 4 нэр томъёо байна. Жишээ нь:
 - $халд + вар = халдвар$ /Тодорхой газарт өвчин үүсгэгч шавж тархан бохирдуулах, хортон тархан бохирдуулах үзэгдэл/ (MNS 3474: 2003)
 - $төл + бөр = төлбөр$ /Авагчийн нэр, хаягийг солих, бусад холбогдох үйлчилгээнд гарч буй тээвэрлэгч байгууллагын зардал/ (MNS 6387-4: 2016)
- Анхдагч үйл язгуурт -вч дагавар залгаж, нэр үг бүтээсэн 9 нэр томъёо байна. Жишээ нь:
 - $торни + вч = торнивч$ /Эх зөгий бойжиж буй битүүмжлэгдсэн том ташаалавч/ (MNS 6827: 2020)
- Анхдагч үйл язгуурт -г дагавар залгаж, нэр үг бүтээсэн 1 нэр томъёо байна.
 - $дэвс + г = дэвсэг$ /Налуу төхөөрөмжийн дээд хэсгийн тогтворыг хангах, эргийн бэхэлгээ, суваг, чулуун өрлөг, налуу газарт гаргасан хэвтээ талбай/ (MNS 6387-1: 2013)
- Анхдагч үйл язгуурт -гч дагавар залгаж, нэр үг бүтээсэн 9 нэр томъёо байна.
 - $тээ + гч = тээгч$ /Соронзон бөөмийн сорилтын нэр томъёо, тодорхойлолт. Эдлэхүүн дээрх урсгалын ойлгын хоёр ба түүнээс олон талбайн нэг/ (MNS ASTM E 269: 2001)
 - $шим + гч = шимэгч$ /Амьд организмыг хэсгээр нь буюу бүхлээр нь тэжээлийн орчин болгон ашигладаг организм/ (MNS 3474: 2003)
- Анхдагч үйл язгуурт -дал⁴ дагавар залгаж, нэр үг бүтээсэн 2 нэр томъёо байна.
 - $зар + дал = зардал$ /Тайлант хугацааны туршид гадагшилсан урсгал,

хөрөнгийн элэгдэл, өр төлбөр бий болох зэргээр өмчийг багасгадаг эдийн засгийн өгөөжийн бууралт/ (MNS 5242: 2003)

- $боо + дол = боодол$ /Шуудангийн бичиг захидал, боодол, илгээлтийн доторх зүйлийг бусдаас тусгаарлан, гаднын элдэв нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий сав баглаа, боодол/ (MNS 0515: 2015)

➤ Анхдагч идэвхтэй үйл язгуурт -*дас* дагавар залгаж, нэр үг бүтээсэн 3 нэр томьёо байна.

- $тайр + дас = тайрдас$ /Унагасан модноос тайрагдсан боловсруулалтын гэмтэл буюу согогтой ёзоор хэсэг/ (MNS ISO 8966: 2002)
- $тайр + дас = тайрдас$ /Вегетативаар үржүүлэхээр бэлтгэсэн модны найлзуур, үндэс, навчийн хэсэг/ (MNS 4118: 1991)

➤ Анхдагч үйл язгуурт -*уур*² дагавар залгаж, нэр үг бүтээсэн 9 нэр томьёо байна.

Жишээ нь:

- $цохь + уур = цохиур$ /Цохиж гал түймэр унтраах багаж/ (MNS 0639: 2016)
- $хэмж + үүр = хэмжүүр$ /<GML>-ийн нэр томьёо, хэмжээсний шугам, эсвэл тодорхой хэмжил зүйн суурь тогтолцооны тоон утгаар илэрхийлэгдэх утга/ (MNS ISO/TS 19104: 2012)

➤ Анхдагч идэвхтэй үйл язгуурт -*лт* дагавар залгаж, нэр үг бүтээсэн 55 нэр томьёо байна.

Жишээ нь:

- $давт + лт = давталт$ /Төслийн зорилго болон төслийн ерөнхий аргазүй өөрчлөгдөхгүйгээр үргэлжилж буй төслийн дараа дараагийн давталт/ (MNS ISO 20252: 2019)
- $холбо + лт = холболт$ /Хоёр зангилаа цэг (B.323)-ийн хоорондох чиглэлт топологийн холболт [уулзвар (B.273)]. Зах (B.151) болон чиглэлээс бүрдэнэ/ (MNS ISO/TS 19104: 2012)

➤ Анхдагч идэвхгүй үйл язгуурт -*лт* дагавар залгаж, нэр үг бүтээсэн 5 нэр томьёо байна.

Жишээ нь:

- $хөлд + лт = хөлдөлт$ /Агаарын температур хэт буурсны улмаас хүний эрүүл мэнд хохирох, мал амьтан хорогдох барилга байгууламж, шугам сүлжээ, эд материал, хөлдөн хэвийн амьдрал алдагдах/ (MNS 6010: 2016)
- $ноц + лт = ноцолт$ /Барилга, барилгын материал, барилгын зураг төсөл, галын норм. Асаах эх үүсвэрийн үйлчлэлээр явагдаж буй шатлагын эхлэл/ (MNS 3838: 1985)

Г. ДҮРСЛЭХ ЯЗГУУР + ДАГАВАР = НЭР ҮГ

➤ Дүрслэх язгуурт – *маг* дагавар залгаж, нэр үг бүтээсэн нэр томьёо 1 байна.

- $ялз + маг = ялмаг$ /Газрын өнгөн хөрсний А давхаргад хуримтлагдаж,

ургамлын үндсээр дамжуулан эд эрхтнийг нь шим тэжээлээр хангагч амьд бие махбодоос гаралтай шим, эрдэс бордоо/ (MNS 5914: 2008)

Судалгааны үр дүн 1

Судалгааны үр дүнгээс үзвэл, бидний бүртгэлээр анхдагч язгуурт дагавар залгаж, нэр үг, үйл үг, тэмдэг нэр бүтээсэн 127 нэр томьёо нь дагаврын аргаар бүтсэн 434 дан бүтэцтэй нэр томьёоны 29.26 хувийг эзэлжээ. Энэхүү нэр томьёонууд нь анхдагч нэр язгуурт *-вч*, *-дэл*, *-ч*, *-чин*, *-нцар* (*-нцэр*) гэсэн дагаврыг, анхдагч тэмдэг нэр язгуурт *-лж*, *-вч* дагаврыг, анхдагч идэвхтэй үйл язгуурт *-аа*, *-аас*, *-бар⁴* (*-вар⁴*), *-вч*, *-г*, *-гч*, *-дал⁴*, *-дас*, *-уур²*, *-лт* дагаврыг, анхдагч идэвхгүй язгуурт *-лт* дагаврыг, дүрслэх язгуурт *-маг* дагаврыг залгаж, нэр үг бүтээсэн байна.

Язгуур + дагавар бүтэцтэй нэр томьёоны бүтцэд илэрсэн дагавруудын давтамжийг тооцоолбол, анхдагч үйл язгуурт залгаж, нэр үг бүтээх үүрэгтэй *-лт* дагавар хамгийн олон буюу 60 удаа (55+5), *-маг*, *-г*, *-лж*, *-вч* зэрэг дагавар хамгийн цөөн буюу нэг удаа илэрчээ.

Аливаа нэр томьёо нь нэр үгээс гадна, тэмдэг нэр, үйл үгээр илэрдэг ч тус санд *язгуур + дагавар* бүтэцтэй дан бүтэцтэй тэмдэг нэр, үйл үг бүхий нэр томьёо бүртгэгдсэнгүй. Харин үйл язгуурт ирээдүй цагаар тодотгон холбох -х нөхцөлийг залгаж, *манах*, *зүсэх*, *уях*, *гарах*, *хандах* зэрэг 18 нэр томьёог бүтээсэн байна. Тэдгээрийн ихэнх нь (MNS 1724: 1973 PC 3315-71) *Баглах. Нэр томьёо, үндсэн ойлголт* гэсэн стандартад, харин “*шатах*” гэсэн нэр томьёо нь (MNS 3838: 1985) *Барилга, барилгын материал, барилгын зураг төсөл, галын норм* гэсэн нэр томьёоны стандартад, “*хандах*” гэсэн нэр томьёо (MNS ISO 2392-1: 1999) *Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томьёо* гэсэн стандартад тус тус нэг нэг удаа илэрчээ.

Түүнчлэн “*цифрэн¹*, *тоон²*” гэсэн үндэс үүсгэх -н залгавар бүтээвэртэй нэр томьёо байгаа нь ухагдахууныг ойлгомжгүй болгож, утга санааг бүрхэгдүүлэх сөрөг нөлөөтэй байгааг харуулж байгаа нь цаашид залруулах асуудлын нэг мөн.

3.2. Үүсмэл үндсэнд залгавар залгаж бүтсэн нэр томьёо

Судалгааны хоёрдугаар хэсэгт бид үүсмэл язгуурт дагавар залгаж үүссэн дан бүтэцтэй нэр томьёонууд нь ямар бүтэцтэй байгааг тодруулав. Үүнд:

- А. Нэр язгуур + дагавар + дагавар = нэр үг
- Б. Нэр язгуур + дагавар + дагавар + дагавар = нэр үг
- В. Нэр язгуур + дагавар + дагавар + дагавар+ дагавар = нэр үг

¹ MNS ISO 2392-1:1999, *Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томьёо, Тооноос тогтсон өгөгдөл*, Мөн ийм өгөгдлийг ашигладаг процесс болон функциональ нэгжид хамаарна.

² MNS ISO 2392-1:1999, *Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томьёо, Тооноос тогтсон өгөгдөл*, Цифрээс тогтсон өгөгдөл, мөн ийм өгөгдлийг ашигладаг процесс болон функциональ нэгжид хамаарна.

- Г. Үйл язгуур + дагавар + дагавар + дагавар = нэр үг
Д. Нэр язгуур + дагавар + дагавар + нөхцөл = үйл үг
Е. Тэмдэг нэр + дагавар + дагавар = нэр үг
Ё. Тэмдэг нэр + дагавар + дагавар + дагавар = нэр үг
Ж. Үйл үг + дагавар + дагавар = нэр үг
З. Дүрслэх язгуур + дагавар + дагавар + нөхцөл = нэр үг
И. Нэр язгуур + дагавар + дагавар = үйл үг
Й. Нэр язгуур + дагавар + ... + нөхцөл залгаж, нэр болон үйл үг бүтээсэн нэр томьёо гэсэн хэдэн хэсэгт авч үзэж, судалгааны үр дүнг өгүүлээ. Үүнд:

А. НЭР ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР = НЭР ҮГ

- *нүүрс + ж + лт = нүүрсжилт* /Органик бодисын бүрэн бус шаталтын буюу задралын үр дүнд үүссэн нүүрстөрөгч/ (MNS 3838: 1985)

Б. НЭР ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР + ДАГАВАР = НЭР ҮГ

- *газар + д + уул + га = газардуулга* /Цахилгаан сүлжээтэй холбох зориулалтын газартай шууд хүрэлцэж байгаа нэг дор байрлуулах зориулалттай нэг ба хэсэг дамжуулагч, электродын нэгдэл/ (MNS 5350: 2003)
- *эрлийз + ж + үүл + лт = эрлийзжүүлэлт* /Амьтан ба ургамлын шинэ үүлдэр, сорт гаргах түүнийг сайжруулах зорилготой амьтан, ургамлын янз бүрийн төрөл зүйлийг эвцэлдүүлэх үйл ажиллагаа/ (MNS 4118: 1991)

В. НЭР ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР + ДАГАВАР + ДАГАВАР = НЭР ҮГ

- *үйл+д+вэр+л+гч = үйлдвэрлэгч* /Барилга ба иргэний барилга байгууламж. Барилгын ажилд (талбайн) гаднаас авч хэрэглэх материал (6.1.1), эдлэхүүн (6.1.2), бүтээц (6.1.3) үйлдвэрлэгч байгууллага, хүн/ (MNS ISO 6701-1: 2010)
- *сор + нз + н + гүй + ж + үүл + лт = соронзонгүйжүүлэлт* /Сорилт. Соронзон бөөмийн сорилтын нэр томьёо, тодорхойлолт. Тодорхой цэг дээр хэмжиж нэгж урт дахь эрстед буюу ампераар илэрхийлсэн соронзон орны эрчим/ (MNS ASTM E 269: 2001)

Г. ҮЙЛ ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР + ДАГАВАР = НЭР ҮГ

- *сал + аа + л + гч = салаалагч* /Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж болон тээврийн хэрэгслийн нэр. Гал түймэр унтраах бодисыг нэг буюу олон чиглэлд өгөх багаж хэрэгсэл/ (MNS 0639: 2016)
- *зас + г + ла + л = засаглал* /Шуудан холбооны нэр томьёо. Байгууллага бүхэлдээ удирдлагатай, зохицуулалттай, хяналттай, хариуцлагатай байх арга зам/ (MNS 0515: 2015)
- *тогтвор + ж + лт = тогтворжилт* /Стандарт, хэмжил зүй. Хадгалалтын тодорхой нөхцөлийг хангасан үед хүчин төгөлдөр хэрэглэх хугацааны туршид хуулбарлагдан гарах хэмжигдэхүүний утга тогтмол байх чанар/ (MNS ISO GUIDE 30: 2005)

- *шингэн + л + гч = шингэлэгч* /Зууралдлагыг бууруулах зориулалтын нэмэлт шингэн/ (MNS ISO 1998-1: 2008)
- *налуу + жс + лт = налуужилт* /Муруйн (В.99) уртаас хамаарах өндрийн өөрчлөлт [ISO19133:2005]/ (MNS ISO/TS 19104: 2012)

Д. НЭР ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР + НӨХЦӨЛ = ҮЙЛ ҮГ

- *төс + өө + л + сөн = төсөөлсөн* /Ажиллагаа нь өөр хэрэгслээр гүйцэтгэгддэг боловч бодит юм шиг төсөөлөгддөг функциональ байгууламжид хамаарна./ (MNS ISO 2392-1: 1999)
- *ширэг+жс+үүл+х=ширэгжүүлэх* /Овоолго ба сэтэрхийн ташлуурыг ширгээр хамгаалах арга/ (MNS 6387-1: 2013)

Е. НЭР ЯЗГУУР + ДАГАВАР + НӨХЦӨЛ = ҮЙЛ ҮГ

- *баадан + на + х = баадагнах* /Хэсэг хэсгээр нь боох/ (MNS 0515: 2015)
- *ломбо+д+х=ломбодох* /Боодлын нэгжид ломбо дарахыг хэлнэ/ (MNS 1724: 1973 PC 3315-71)

Ё. НЭР ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР = ҮЙЛ ҮГ

- *таг + л + аа = таглаа* /Гал түймэр унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн битүүмж, аюулгүй ажиллагааг хангах эд анги/ (MNS 0639: 2016)

Ж. НЭР ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР + ДАГАВАР + НӨХЦӨЛ = ҮЙЛ ҮГ

- *хор + гүй + жс + үүл + х = хоргүйжүүлэх* /Химийн бохирдолтод өртсөн газрын гадаргуу, агаар, ус, ургамал болон хүнс тэжээл зэргийн хордолтын хэмжээг зөвшөөрөгдсөн түвшинд хүртэл багасгах ажиллагааг/ (MNS 6010: 2016)
- *ус + гүй + жс + үүл + х = усгүйжүүлэх* /Стандартын нөхцөлд газрын тосны бүтээгдэхүүнийг устай холин демэмульгатор нэмсний дараа бүтээгдэхүүн усаа тунгаах чадварын туршилт/ (MNS ISO 1998-2: 2008)

З. ТЭМДЭГ НЭР + ДАГАВАР + ДАГАВАР + ДАГАВАР = НЭР ҮГ

- *тод + р + уул + га = тодруулга* /Аливаа хэсэг зүйл (В.269)-ын бүртгэлд (В.390) мөн чанарт нь үл нөлөөлөх тодотгол оруулах/ (MNS ISO/TS 19104: 2012)
- *эсрэг + үү + ц + л = эсрэгцүүлэл* /Аль нэг хязгаарын төлөвтэй холбоотой ямар нэг шалгуурын үед хэрэглэнэ/ (MNS ISO 8930: 2001)

И. ҮЙЛ ҮГ + ДАГАВАР + ДАГАВАР = НЭР ҮГ

- *сал + аа + л + гч = салаалагч* /Гал түймэр унтраах бодисыг нэг буюу олон чиглэлд өгөх багаж хэрэгсэл/ (MNS 0639: 2016)

- *зас + з + ла + л = засаглал* /Байгууллага бүхэлдээ удирдлагатай, зохицуулалттай, хяналттай, хариуцлагатай байх арга зам/ (MNS 0515: 2015)

Й. ДҮРСЛЭХ ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР = НЭР ҮГ

- *бут + л + уур = бутлуур* /Ширхгийн материалыг жижиг ширхэглэлтэй болгон буталдаг төхөөрөмж/ (MNS ISO 11375: 2000)

К. ДУУРАЙХ ЯЗГУУР + ДАГАВАР + ДАГАВАР + НӨХЦӨЛ = НЭР ҮГ

- *ховх + ч + уур = ховхчуур* /Даатгалтай буюу үнэ зарласан илгээмжийг битүүмжлэх лац/ (MNS 0515: 2015)
- *цоо + л + гч = цоологч* /Хийц бүтээцийг цоолж, нүхлэх багаж/ (MNS 0639: 2016)

Судалгааны үр дүн 2

Бидний бүртгэлээр үүсмэл язгуурт дагавар залгаж бүтээсэн 307 нэр томьёо илэрсэн нь дагаврын аргаар бүтсэн дан бүтэцтэй нэр томьёоны 70.74 хувийг эзэлжээ. Энэ нь анхдагч язгуурт дагавар залгаж үүссэн нэр томьёоноос даруй 3 дахин байна.

Судалгааны үр дүнгээс үзвэл, “*нэр язгуур + дагавар + дагавар*” бүтэцтэй үгс хамгийн олон, “*дүрслэх язгуур + дагавар + дагавар*” бүтэцтэй үгс хамгийн цөөн илэрчээ. Залгавар тус бүрийн давтамжийн тооцоолж, хамгийн их давтамжтай 5 дагаврыг танилцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- үйлээс нэр үг бүтээх *-лт* дагавар 143 удаа,
 - үйлээс нэр үг бүтээх *-л* дагавар 95 удаа,
 - нэрээс үйл үг бүтээх *-л* 88 удаа,
 - үйлээс нэр үг бүтээх *-гч* дагавар 72 удаа,
 - үйлээс нэр үг бүтээх *-уур* дагавар 17 удаа, *-үүр* дагавар 12 удаа давтагджээ.
- Харин
- дүрслэх язгуураас нэр үг бүтээх *-маг*³ дагавар 1 удаа,
 - үйлээс нэр үг бүтээх *-лого*⁴ дагавар 1 удаа,
 - нэрээс тэмдэг бүтээх *-тэй*⁵, *-гүй*⁶ дагавар 1, 1 удаа илэрсэн нь хамгийн цөөн давтамжтай байна.

³ MNS 2920 : 1980, *Уул уурхай, ашигт малтмал. Нүүрс*, Нүүрс үүсэх үе шатны явцад үүссэн хүлэр.

⁴ MNS 4967 : 2000, *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн нэр томьёо*, Химийн хорт цацраг болон биологийн идэвхт бодис зэрэг гаднын биет хүний бие махбодод янз бүрийн замаар нэвтрэн орж сөрөг нөлөө үзүүлэх (өвчлүүлэх)-ийг хордлого гэнэ. Хордлого нь хурц, архаг гэж 2 янз байна.

⁵ MNS ISO 2392-1:1999, *Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томьёо*, Хугацааны ерөнхий дохио мэтийн тусгай үзэгдлээс хамаардаг хоёр буюу түүнээс дээш процесст хамаарна.

⁶ MNS ISO 2392-1:1999, *Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томьёо*, Хугацааны ерөнхий дохио мэтийн тусгай үзэгдлээс хамаардаггүй хоёр буюу түүнээс дээш процесст хамаарна.

Нэр томьёоны санд язгуурын араас хамгийн олон залгавар залгаж бүтээсэн нэг нэр томьёо илэрсэн нь “*Cor + нз + н + гүй + ж + үүл +лт*” бөгөөд (MNS ASTM E 269: 2001) стандартын Сорилт. Соронзон бөөмийн сорилтын салбарын “Тодорхой цэг дээр хэмжиж нэгж урт дахь эрстед буюу ампераар илэрхийлсэн соронзон орны эрчим.” гэсэн утгатай нэр томьёо ажээ.

Тус нэр томьёоны санд “*шатлага*”⁷, “*төсөөлсөн*”⁸, “*зөвшөөрөгдсөн*”⁹ гэсэн нэр томьёонуудыг ухагдахууныг тодорхой болгох үүднээс дахин тодорхойлолт, оноолт дээр мэргэжлийн үүднээс хандах шаардлагатай байна.

Бидний бүртгэлээр нэр үгээр илэрсэн нэр томьёо үйл үг болон тэмдэг нэрээс олон байгаа нь үгийн сангийн чухал хэсэг төдийгүй өгүүлбэр зүйд зохион байгуулах төв болдог үйл үгийг цөөрүүлэх болно гэсэн Ш.Лувсанвандан (1987), нэр томьёо бол онцгой үүрэг гүйцэтгэхээс биш, онцгой үг огт биш, өгүүлбэрт бусад үгтэй л нэгэн адил ямар нэгэн гишүүн болдог гэж үзсэн Ц.Шагдарсүрэн (2009), нарын саналыг дэмжиж байна.

4. Дүгнэлт

Монгол хэлний үг, нэр томьёо бүтэх ёс, үгийн бүтэц, дагаврын байр, хэрэглээний талаар бичсэн ганц сэдэвт хамтын бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл цөөнгүй байгаа нь бидний судалгааны ажилд онол арга зүйн хувьд чиг баримжаа боллоо.

Бидний “Монгол нэр томьёоны стандартын судалгаа (Нэр томьёог боловсруулах арга, зарчмын олон улсын стандартыг нутагшуулах)” суурь судалгааны төслийн хүрээнд Монгол Улсад ашиглаж буй 85 стандартаар бүрдүүлсэн 10387 стандартчилсан нэр томьёоны санд түшиглэж хийсэн дан бүтэцтэй нэр томьёоны бүтцийн судалгаа нь нэр томьёог зөв оноож, боловсруулж хэрэглэхэд нэн чухал ач холбогдолтой юм.

Судалгааны үр дүн хэсэгт дурдсан буруу оноосон нэр томьёоноос гадна нэр томьёог бүтээлцэж байгаа -лт дагаврын давтамж, хэрэглээ бусад залгавраас харьцангуй их байгаа нь монгол хэлэнд үйл үг идэвхтэй хэрэглэдэг язгуур онцлогийг балархайтуулах сөрөг нөлөөтэй тул хэрэглээг хязгаарлах, стандартчилсан нэр томьёог дахин нягталж, шинээр оноож, тогтоож, боловсруулахад анхаарлаа хандуулах шаардлагатай нь ажиглагдлаа.

⁷ MNS 3838 : 1985, *Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм*, Нэр томьёо, тодорхойлолт. Бодис нь хүчилтөрөгчтэй харилцан үйлчлэхдээ, дулаан, утаа, ялгаруулж, дөл болон уугилт үүсгэхийг хэлнэ.

⁸ MNS ISO 2392-1:1999, *Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томьёо*, Ажиллагаа нь өөр хэрэгслээр гүйцэтгэгддэг боловч бодит юм шиг төсөөлөгддөг функциональ байгууламжид хамаарна.

⁹ MNS 4673 : 1998, *Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа*.

Талархал

Бид тус өгүүллээ Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны санхүүжилтээр 2022-2024 онд хэрэгжиж буй [№ ШУТБИХХЗГ-2022/196] “Монгол нэр томъёоны стандартын судалгаа (Нэр томъёо боловсруулах арга, зарчмын олон улсын стандартыг нутагшуулах)” төслийн хүрээнд бичсэн бөгөөд стандартын нэр томъёоны цахим сан бүрдүүлэхэд хамтран ажилласан Стандарт хэмжил зүйн газар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын алба болон энэхүү судалгааг хийхэд үнэтэй заавар, зөвлөгөө өгч, онолын ном бүтээлээр хангаж дэмжин ажилласан, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Компьютер хэл шинжлэлийн салбарын хамт олонд талархсан сэтгэлээ илэрхийлье.

Ном зүй

Батбямба, Т. (2023). Стандарт дахь нэр томъёоны бүтцэд хийсэн тоон шинжилгээ. *Хэрэглээний хэл шинжлэл*, VIII (23):16-25. [Batbyamba, T. Quantitative Analysis on Terminology Structure in Terminology Standarts, *Heregleenii hel shinjlel*, 2023, VIII(23): 16-25.]

Шагдарсүрэн, Ц. (2009). Нэр үгийн -лт дагавар болон үйл үгийн -х бүхий хэлбэрийн хэрэглээ хийгээд мөн чанар. *Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл соёлын сургууль, эрдэм шинжилгээний бичиг*, Боть. XXX(318), 139-145. [Shagdarsüren, Ts. Characteristic and usage of verb form “-х”, affix “-лт” of noun, *Journal of Mongolian Studies, Tom. XXX(318)*, 139-145.]

Лувсанвандан, Ш. (1987). Нэр томъёоны тухай асуудалд. Боть XIII(21), [Luvsanvandan, Sh. Issue of terminology. *Studia Mongolica, Tom. XIII(21)*, 6-7.]

Цахим холбоос:

<http://172.104.34.197/nlp-web-demo/>

[https://www.laurenceanthony.net/software/antconcl/](https://www.laurenceanthony.net/software/antconc/)

Стандарт

MNS 5914: 2008 *Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт*

MNS ISO 6701-1: 2010 *Барилга ба иргэний барилга байгууламж*

MNS ISO 11375: 2000 *Барилгын машин төхөөрөмж*

MNS ISO 8930: 2001 *Бүтээцийн найдваршлын ерөнхий зарчим*

MNS ISO/TS 19104: 2012 *Газар зүйн мэдээлэл*


MNS 3472: 1983 *Газар тариалан*

MNS ISO 1998-5: 2008 *Газрын тосны аж үйлдвэр*

MNS 0639: 2016 *Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо*

MNS 6010: 2016 *Гамигийн холбогдолтой нэр томъёо*

- MNS 3951: 1986 *Геодез, Нэр томъёо, тодорхойлолт*
- MNS ISO 20252: 2019 *Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа нэр томъёо*
- MNS 6827: 2020 *Зөгийн аж ахуй*
- MNS 2494: 2010 *Зүсмэлийн үйлдвэрийн нэр томъёо*
- MNS ISO 8966: 2002 *Мод бэлтгэх аж үйлдвэрийн нэр томъёо*
- MNS ISO 2392-1: 1999 *Мэдээллийн технологийн үндсэн ба ерөнхий нэр томъёо*
- MNS 3843: 1985 *Нэхий эдлэл ба түүний эд ангийн нэр томъёо*
- MNS 5242: 2003 *Нягтлан бодох бүртгэлийн нэр томъёо*
- MNS ISO 3877-1: 2014 *Резин дугуй, хийлэх хошуу болон дотуур хаймар*
- MNS ISO GUIDE 30: 2005 *Стандарт, хэмжил зүй*
- MNS ASTM E 269: 2001 *Сорилт. Соронзон бөөмийн сорилтын нэр томъёо, тодорхойлолт*
- MNS ISO 10185: 2012 *Тамхи, тамхин бүтээгдэхүүн*
- MNS 6387-1: 2013 *Төмөр зам. Зам. Замын аж ахуйн нэр томъёо*
- MNS 6387-4: 2016 *Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томъёо*
- MNS 6387-3: 2013 *Хөдлөх бүрэлдэхүүний нэр томъёо*
- MNS 4118: 1991 *Хөдөө аж ахуй. Ойн аж ахуй*
- MNS 5350: 2003 *Цахилгаан станц. Цахилгаан шугам сүлжээ*
- MNS 4673: 1998 *Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа*
- MNS 3474: 2003 *Ургамал хамгаалал*
- MNS 6279: 2011 *Ус хангамж, ариун цэврийн байгууламж*
- MNS 2920: 1980 *Уул уурхай, ашигт малтмал*
- MNS 0515: 2015 *Шуудан холбооны нэр томъёо*
- MNS 2919: 2003 *Эрчим хүч ба дулаан дамжуулах техник*



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.